ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН ЯВЦЫН ТАЙЛАН

2018 - 10 -15

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН ЯВЦЫН ТАЙЛАН

2018 - 10 - 15

Агуулга

1. **Төслийн танилцуулга**
2. **Барилга угсралт**
3. **Худалдан авалт**
4. **Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлт**
5. **Төслийн санхүүжилт**
6. **Дүгнэлт, асуудлууд**

1. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Санхүүжилтийн эх үүсвэр:	Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны хөнгөлөлттэй зээл Монгол Улсын Засгийн Газар - Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын Хөрөнгө оруулалт	
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар	
Төслийн өртөг:	**Нэгдүгээр үе шат:** АХБ-наас 19.78 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 27.5 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл, 3.7 сая ам.долларын буцалтгүй тусламж; ЕХОБ-наас 22.01 сая долларын зээл; Монгол улсын Засгийн газраас 33.15 сая ам доллар; **Нийт 106.14 сая ам доллар.**	**Хоёрдугаар үе шат:** АХБ-наас 29.24 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 37.11 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл; ЕХОБ-наас 19.64 сая еврогийн зээл; Монгол улсын Засгийн газраас 35.15 сая ам доллар; **Нийт 121.14 сая ам доллар.**
Төслийн хугацаа:	Нэгдүгээр үе шат: **2014.09.01 – 2019.12.31**	Хоёрдугаар үе шат: **2017.12-р сар - 2021.8-р сар**
Төслийн явц:	Нэгдүгээр үе шат: **57.78 хувь**	Хоёрдугаар үе шат: **10 хувь**

2. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ БА ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

1 СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ДУЛААНЫ СТАНЦ

Гэрээний дугаар:	SHF06
Гүйцэтгэгч:	“Хүрд” ХХК, “Шиншиан Гонгшен бойлер” ХХК-ийн түншлэл
Байршил:	Сүхбаатар дүүрэг 13-р хороо
Хүчин чадал:	26.68 МВТ
Гэрээний хугацаа:	2017.07.17-аас 2019.10.15
Ажлын явц:	10%

Дулааны станцын барилгын суурийн цутгалтын ажил

Дулааны станцын ажлын зураг төсөл боловсруулагдсан. Эрчим хүчний төвийн магадлалаар хянагдаж байна. Дулааны станцын барилга архитектор болон барилга бүтцийн магадлалаар хянуулсан.

2 Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил 2-р үе шат

Гэрээний дугаар:	SRDH14
Гүйцэтгэгч:	“Набсан” ХХК, “Тэргүүн инвест” ХХК, “Тэгш плант” ХХК түншлэл
Байршил:	Чингэлтэй дүүргийн 14, 18-р хороо, Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо
Хүчин чадал:	• Авто зам 1.9 км • Үерийн ус зайлуулах суваг 2.4 км • Гудамжны гэрэлтүүлэг 4.7 км • Цэвэр усны шугам хоолой 2.0 км • Бохир усны шугам хоолой 4.2 км • Дулаан дамжуулах шугам хоолой 4.6 км
Гэрээний хугацаа:	2017.11.09-аас 2019.11.09
Ажлын явц:	28%

Сэлбэ дэд төв / SRDH14/ ийн бохир усны шугамын угсралтын ажил

Сэлбэ дэд төвийн /SRDH14/ Ус дулаан дамжуулах төв -№13-ийн барилгын суурийн угсралтын ажил

3 Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил Ye шат 1

Гэрээний дугаар:	SRDH11
Гүйцэтгэгч:	“Вайт финикс” ххк, “Хасу мегаватт” ххк, “Эвт трак” ххк түншлэл
Байршил:	Чингэлтэй дүүргийн 14, 18-р хороо, Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо
Хүчин чадал:	• Авто зам 3.7 км • Үерийн ус зайлуулах суваг 2.0 км • Гудамжны гэрэлтүүлэг 7.5км • Цэвэр усны шугам хоолой 3.9 км • Бохир усны шугам хоолой 5.5 км • Дулаан дамжуулах шугам хоолой 4.4 км
Гэрээний хугацаа:	2018.02.23-аас 2019.10.23
Ажлын явц:	28%

Сэлбэ дэд төвийн / SRDH11/ Дулааны шугамын угсралтын ажил

Сэлбэ дэд төвийн /SRDH11/ Ус дулаан дамжуулах төв -3-ийн барилгын суурийн угсралтын ажил

4 Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил

Гэрээний дугаар:	BHF06
Гүйцэтгэгч:	“Чмм” ХХК, “Эс Энд Эй трейд” ХХК түншлэл
Байршил:	“Хөрс” худалдааны төвөөс ханын материал хүртэл
Хүчин чадал:	• 2ф500мм шугамыг 2ф700 болгох 2.1 км • 2ф400мм шугамыг 2ф600 болгох 1.2 км • Өргөлтийн насос станц 550м3/ц н=53м
Гэрээний хугацаа:	2018.03.24-аас 2019.08.15
Ажлын явц:	68%

Дулааны 11и магистраль 2ф500мм-ийн 1,6 км шугамыг буулгаж 2ф700мм болгон өргөтгөн, шинэчлэх ажлыг бүрэн хийж дуусгасан. Тохижилт нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. 2019 оны 05 сард 2ф400мм-ийн 1,6км шугамыг буулгаж 2ф600мм болгон өргөтгөн, шинэчилнэ.

5 Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:	BSF05, Lot-1
Гүйцэтгэгч:	“Ус орчин ” ХХК
Байршил:	БАЯНХОШУУ ДЭД ТӨВ
Хүчин чадал:	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга
Гэрээний хугацаа:	2017.10.05-аас 2018.10.30
Ажлын явц:	85%

Одоогийн байдлаар барилгын суурь, каркас цутгалт, өрлөг шавардлагын ажил бүрэн дуусч, гадна тохижилтын ажил хийгдэж байна. Барилга угсралт 85%-тай хэрэгжиж байгаа ба 2018 оны IV улиралд бүрэн дуусгаж ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

6 Баянхошуу дэд төвд барих бизнес инкубатор, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга

Гэрээний дугаар:	BSDF05, Lot 2
Гүйцэтгэгч:	“Томо бьюлдинг” ХХК
Байршил:	БАЯНХОШУУ ДЭД ТӨВ
Хүчин чадал:	Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга
Гэрээний хугацаа:	2017.10.08-с 2018.12.01
Ажлын явц:	60%

2018.09.30-ны өдрийн байдлаар барилгын арагт бүтээцийн угсралт, өрлөгийн ажил бүрэн дуусч. Барилга угсралтын явц 60 орчим хувьтай байна.

7 Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил

Гэрээний дугаар:	WWTPR01
Гүйцэтгэгч:	“Эс энд эй трейд” ХХК, “Набсан” ХХК-ийн түншлэл
Байршил:	СХД-ийн 20-р хороо
Гэрээний хугацаа:	2017.09.14-аас 2018.12.01
Ажлын явц:	57%

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилгыг дотор инженерийн шугам сүлжээний хамт шинэчлэн барих болон аэротанкийн бетон хийцийн эвдрэлийг засах, цэвэрлэгээний чанарыг сайжруулах агаарын диффузер, селектор нэмж суурилуулах ажлын гүйцэтгэл 57%-тай үргэлжилж байна.

8 Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:	WSNR17C
Гүйцэтгэгч:	"Модерн Хас" ХХК, "Монгол Менежмент Төв" ХХК-ийн түншлэл
Байршил:	Орос 14-р сургууль орчим
Хүчин чадал:	543 метр урттай Ф400мм-ийн ОКП146100 резинэн жийргэвчтэй ширмэн хоолой
Гэрээний хугацаа:	2017.11.05-аас 2018.10.11
Ажлын явц:	• Барилга угсралтын ажил-34% • Материал ханган нийлүүлэлт- 100%

9 Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:	BSDF07, Lot 1
Гүйцэтгэгч:	"Хангилцаг " ХХК
Байршил:	БАЯНХОШУУ ДЭД ТӨВ
Хүчин чадал:	2.3 км үерийн хамгаалалтын суваг
Гэрээний хугацаа:	2017.12.06-аас 2018.10.30
Ажлын явц:	100%

Хангилцаг ХХК гүйцэтгэж буй Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажлын нийт гүйцэтгэл 100% байна.

10 Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:	BSDF07, Lot 2
Гүйцэтгэгч:	“Экспресс зам” ХХК
Байршил:	Сүхбаатар дүүрэг
Хүчин чадал:	2,4 км үерийн хамгаалалтын суваг
Гэрээний хугацаа:	2017.11.21-аас 2018.11.06
Ажлын явц:	65%

Экспресс зам ХХК-ний гүйцэтгэж буй Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 65 хувьтай байна. Үерийн хамгаалалтын цутгамал сувгийн ажлын явц 75%, угсармал сувгийн ажил 42% тай байна. Суваг 6 ба 7 ийн ажлууд нь зам дагуу хийгдэх тул “Вайт финикс” ХХК-ний ажилтай уялдуулан хийхээр хүлээж байна.

11 Баянхошуу дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Гэрээний дугаар:	BSWR10, Lot 1
Гүйцэтгэгч:	“Бумбод” ХХК, “Одкон” ХХК түншлэл
Байршил:	Баянгол дүүрэг, 22 хороо, Самбалүндэв уулын оройд
Хүчин чадал:	• 1000 м3 усан сан • Өргөлтийн насос станц • Ус дамжуулах хоолой
Гэрээний хугацаа:	2017.12.20-аас 2019.06.05
Ажлын явц:	• 1000 м3 усан сан - 5% • Өргөлтийн насос станц - 60% • Ус дамжуулах хоолой - 100%



1000 м3 усан сан

Өргөлтийн насос станц

Ус дамжуулах хоолой

12 Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх HDPE ф900мм-ийн 4010 метр цэвэр ус дамжуулах гол шугамын болон ф600мм-ийн 1684.23 метр урт “9б” бохир ус зайлуулах зөөлөн ширмэн яндан хоолой шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар: WSNR17A

Гүйцэтгэгч: “Грийн ресурс” ХХК

Байршил: КТМС-н усан сангаас 100 айл, Баянбүрдийн тойрог хүртэл

Хүчин чадал:
- ф900мм-н цэвэр ус дамжуулах Hdpe хоолой – 4010м
- ф600мм-н бохир ус зайлуулах зөөлөн ширмэн хоолой – 1684.23м

Гэрээний хугацаа: 2018.02.07-аас 2019.01.23

Ажлын явц:
- Барилга угсралтын ажил-14%
- Материал ханган нийлүүлэлт- 100%

Материал татан авалт дуусч, худаг холболтын ажил үргэлжилж байна.

13 Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус дамжуулах шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил

Гэрээний дугаар:	BSWR10, Lot 2
Гүйцэтгэгч:	“Санжат” ХХК
Байршил:	Сүхбаатар дүүрэг
Хүчин чадал:	• 1000 м3 усан сан • Насос станц • Цэвэр усны шугам
Гэрээний хугацаа:	2018.03.23 - 2019.09.23
Ажлын явц:	65%

Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус дамжуулах шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажлын шугам суурилуулалт хийгдэж, усан сангийн тохижилтын ажил хийж байна. Нийт ажлын явц 65%тай хэрэгжиж байна.

14 Улаанбаатар хотын Тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил

Гэрээний дугаар:	WSWR17B
Гүйцэтгэгч:	“Мон инж бар" ХХК
Байршил:	КТМС-н усан сангаас 100 айл, Баянбүрдийн тойрог хүртэл
Хүчин чадал:	• ф630мм-н цэвэр ус дамжуулах Hdpe хоолой – 8070 м • Холбох хэрэгсэл
Гэрээний хугацаа:	2018.03.23 - 2019.09.23
Ажлын явц:	• Барилга угсралтын ажил - 14% • Материал ханган нийлүүлэлт - 100%

Бараа материал татан авалт хийж, шугам суурилуулалтын ажил хийж байна.

15 УСУГ үйл ажиллагаа сайжруулах төсөл

Гэрээний дугаар: WSWR17B

Гүйцэтгэгч: “Комфорт Импекс” ХХК

Ажлын явц: 90%

УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төслийн хүрээнд Үйлдвэр, Мах, Төв болон Гачуурт насос станцуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, түгээх сүлжээний удирдлагын болон хэмжих худгуудын барилга угсралт, УСУГ-ын төвд удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдлыг илрүүлэх систем суурилуулж ашиглалтанд оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Шилэн кабель суурилуулалтын ажил хийгдэж дууссан. Үйлдвэрийн станцын удирдлагын системийг ашиглалтад оруулж ажиллагааг жигдрүүлснээр 1 ба 2-р өргөгчийн насос станцыг хянан удирдаж байна. Хяналтын хаалт угсралтын шинэчилсэн графикийг холбогдох хүмүүсээр батлуулан ажиллаж байна. УСУГ нэгдсэн удирдлагын төвийн програм хангамжийн ажлын гүйцэтгэл 50%-тай байна

3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн I үе шатны хүрээнд нийт 31 багц ажил байгаагаас 2018 оны 09-р сард 21 багц ажлын гэрээ хийгдэж ажлаа эхлүүлсэн. Үүнээс 3 багц ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан.
Төслийн Худалдан Авах Ажиллагаа (ХАА) нь Нийслэлийн Худалдан Авах Ажиллагааны Газраар (НХААГ) дамжих үйл явцыг зогсоож ХАА-ааг Төсөл хэрэгжүүлэгч нэгж (ТХН)-д 2018 оны 7-р сараас эхлэн шилжүүлсэн нь ажлыг богино хугацаанд хэрэгжүүлэх боломж бүрдүүлж Азийн Хөгжлийн Банк (АХБ), ТХН болон НЗДТГ хооронд олон шатлал дамжих шаардлагагүй болсон.
Одоогоор Төслийн 1-р үе шатны ХАА-ны хүрээнд үнэлгээний шатанд явагдаж буй нийт 6 тендер, зарлагдах нийт 1 тендер байна. Үүнд:

Үнэлгээний шатанд:

1. Баянхошуу дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил (Үе шат 1)–ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2017 оны 5-р сарын 12-нд анх зарлаж, 2017 оны 7-р сарын 6-нд тендер хүлээн авч, нээсэн. 2 тендерт оролцогчидтой уг сонгон шалгаруулалтын Тендерийн үнэлгээний тайланг 2017 оны 9-р сарын 14-нд АХБ-руу илгээсэн ба АХБ-аас 9-р сарын 18-нд ирсэн тодруулгын дагуу хариу бэлдэж 2017 оны 12-р сарын 19-нд АХБ-руу илгээсэн. АХБ-аас 2018 оны 2-р сарын 18-нд дахин тодруулга ирсний дагуу 2018 оны 3-р сарын 20-нд Үнэлгээний тайланг дахин хянаж явуулсан. 2 тендерт оролцогчдын ирүүлсэн тендер нь шаардлагад нийцээгүй тул АХБ-аас 2018 оны 5-р сарын 18-нд дахин зарлах тухай зөвшөөрөл ирсэн. Уг тендерийг 2018 оны 5-р сарын 21-нд дахин зарласан ба тендерийн баримт бичиг худалдан авсан компаниудаас ирсэн хүсэлтийг үндэслэж, тендер хүлээн авах хугацаа 7-р сарын 2 байсныг 7-р сарын 9 болгож сунгасан. Үнэлгээний тайланг боловсруулж АХБ-руу 8 сарын 15-нд илгээсэн. АХБ-аас тодруулга ирсний дагуу үнэлгээний тайланг дахин хянаж 9-р сарын 29-нд илгээгээд хянуулж байна.

2. Баянхошуу дэд төвийн үерийн далан дагуух тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2017 оны 12-р сарын 22-нд зарлаж, 2018 оны 2-р сарын 6-нд тендер хүлээн авсан. Үнэлгээний хороо ажиллан үнэлгээ хийж, тайлан боловсруулж байна.

3. Сэлбэ дэд төвийн үерийн далан дагуух тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2017 оны 12-р сарын 22-нд зарлаж, 2018 оны 2-р сарын 6-нд тендер хүлээн авсан. Үнэлгээний хороо ажиллан үнэлгээ хийж, тайлан боловсруулж байна.

4. Баянхошуу дэд төвийн гадна цахилгаан, шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 2-р сарын 14-нд зарлаж, 3-р сарын 28-нд тендер хүлээн авч нээсэн. Үнэлгээний тайланг боловсруулж, АХБ-руу 7-р сарын 27-нд хүргүүлж, хянуулж байна.

5. Сэлбэ дэд төвийн гадна цахилгаан, шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 2-р сарын 26-нд зарлаж, 4-р сарын 9-нд тендер хүлээн авч нээсэн. Үнэлгээний тайланг боловсруулж, АХБ-руу 5-р сарын 30-нд илгээсэн ба АХБ-аас 8-р сарын 10-нд ирсэн тодруулгын дагуу Үнэлгээний тайлангаа дахин хянаж, 9-р сарын 27-нд илгээн хянуулж байна.

6. Сэлбэ дэд төвд баригдах цэцэрлэг, бизнес инкубатор болон мэргэжлийн сургалт үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг анх 2017 оны 9-р сарын 6-нд зарлаж, 10-р сарын 9-нд тендер хүлээн авсан. Үнэлгээний тайланг боловсруулж АХБ-руу 2018 оны 1-р сарын 17-нд илгээж, тодруулгын дагуу үнэлгээний тайланг дахин хянаж илгээсэн. Хоёр тендерт оролцогчийн 1 нь АХБ-ны хар жагсаалтад орсон тул тендерт оролцох эрх бүхий этгээд биш, 2 дахь оролцогч нь тендерийн хүчинтэй хугацаа сунгахаас татгалзсан учраас АХБ-аас тендерийг хүчингүй болгож, дахин зарлах зөвшөөрөл 2018 оны 6-р сарын 15-нд олгосны дагуу 2018 оны 7-р сарын 2-нд дахин зарлаж, 8-р сарын 3-нд тендер хүлээн авсан. 1-р багц буюу ‘цэцэрлэгийн барилга угсралтын ажил’-ын сонгон шалгаруулалтад 4 тендерт оролцогчид, 2-р багцад буюу ‘бизнес инкубатор болон мэргэжлийн сургалт үйлчилгээний төвийн барилга угсралтын ажил’-ыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтад 3 тендерт оролцогчид саналаа ирүүлсэн. Үнэлгээний тайланг боловсруулж АХБ-руу хянуулахаар 9 сарын 13-нд илгээн, хянуулж байна.

4. ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ БА НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

Монгол улсын засгийн газар (МУЗГ) болон Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хооронд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-т зааснаар Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийг АХБ-ны “Хамгааллын бодлого”-ын дагуу боловсруулсан “Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг”-т нийцүүлэн гүйцэтгэх ба тус ажилтай холбогдон гарах зардлыг МУЗГ бүрэн хариуцах үүрэгтэй.
Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг буюу Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (ГЧНШТ)-г батлагдсан зураг төслийг үндэслэн Нийслэл болон түүний харьяа байгууллагууд боловсруулан АХБ-аар хянуулж батлуулах үүрэгтэй.
Тус үүргийн дагуу төслийн 1 дүгээр үе шатны хувьд дараах 7 төлөвлөгөө боловсруулан батлууллаа. Үүнд:

1. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд баригдах Дулааны станц, Цэцэрлэг, Бизнес инкубатор болон сургалтын төвийн ажлын нийцтэй байдлын дүн шинжилгээний тайлан (НБДШТ)-2018 оны 10 сард
2. Баянхошуу дэд төвийн зам болон дэд бүтцийн ажлын ГЧНШТ-2018 оны 8 сард
3. Сэлбэ дэд төвийн зам болон дэд бүтцийн ажлын ГЧНШТ-2018 оны 8 сард
4. Баянхошуу дэд төвийн усан сан, насос станц, шугам хоолойн ажлын ГЧНШТ-2018 оны 8 сард
5. Сэлбэ дэд төвийн усан сан, насос станц, шугам хоолойн ажлын НБДШТ -2017 оны 9 сард
6. Зүүн дүүргийн усан сан –Тасганы Овооны усан сан-Баруун дүүргийн усан санг холбох цэвэр усны шугамын ажлын ГЧНШТ-г боловсруулж байгаа ба ажлын явц 95%
7. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанд холбох шугам болон насос станцын ажлын ГЧНШТ-г боловсруулж дуусан. АХБ-ны төв оффис дахь бүс нутаг хариуцсан нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн болон Байгаль орчин, нийгэм хамгааллын газрын мэргэжилтнүүдийн саналыг авахаар 2018 оны 7 дугаар сарын 23 нд хүргүүлсэн бөгөөд ажлын явц 95%

А. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Төслийн 1 дүгээр үе шатны газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн явц 2018 оны 09 сарын 30-ны байдлаар:

- 734 нэгж талбарын эзэдтэй зөвшилцөлд хүрснээс
- 630 нэгж талбарын нөхөн олговор олгох тухай НЗД-ын захирамж гарч
- 466 нэгж талбарын нөхөн олговор олгогдоод байна.

Иргэдтэй зөвшилцөх ажлын явц 90% боловч нийт зөвшилцсөн иргэдийн нөхөн олговор олгох ажлын явц 74%-тай байна.

Б. Нөлөөлөлд өртсөн иргэдээс ирсэн санал, гомдол

Дэд төвүүдийн оршин суугч иргэдийн гаргасан 138 гомдлыг 100% шийдвэрлэсэн. Нийт гомдлуудыг ангилж үзвэл:

- Үнэлгээтэй холбоотой -81
- Төсөлд газраа бүтнээр нь өгөх хүсэлт -20
- Барилгын ажлын явцын талаар -3
- Төсөлд оролцохоос татгалзсан -3
- Түр суурьшуулах байранд байрлах хүсэлт -14
- Газар авах хүсэлт -17

5. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 09 дугаар сарын 30-ны байдлаар төслийн Сангийн яамны гадаад зээлийн эх үүсвэрийн төсвөөс зарцуулсан төслийн гүйцэтгэл нийт 12.8 тэр бум төгрөг, Сангийн яаманд хянагдах шатанд байгаа төлөгдөөгүй төлбөр нийт 4.07 тэрбум төгрөгийн, НЗДТГ-т хянагдах шатанд буй 1.05 тэрбум төгрөгийн төлбөрийн хүсэлтүүд тус тус ЕХОБ-аас хийгдэх гурав дахь удаагийн татан авалтыг хүлээж байна.

2018 оны 09 дугаар сарын байдлаар хүлээгдэж буй төлбөрийн хэмжээ 2.5 сая ам.доллар буюу ойролцоогоор 7.4 тэрбум төгрөг, гадаад зээлийн ашиглалтын хэмжээ 12.8 тэрбум болж байгаа нь батлагдсан төсвөөс 2.3 дахин их хэмжээгээр илүү байгааюм. Гэвч зөвхөн ЕХОБ-аас санхүүжиж байгаа барилга угсралтын ажлын төлбөрт төлбөл зохих шаардагдах төсвөөс 7.4 тэрбум төгрөгөөр бага байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс Сангийн яамны төсвийн хязгаарлалтаас шалтгаалан цаашид гүйцэтгэгчдэд төлбөр төлөх боломжгүй нөхцөл байдал үүсээд байгаа нь төлөвлөгдсөн барилгын ажлуудыг хойшлуулах, улмаар төсөл хугацаандаа хэрэгжихгүй байх өндөр эрсдэлийг үүсгэсэн.

Азийн Хөгжлийн банк МОН-3098 хөнгөлөлттэй зээл



Гэрээний дүн
25,234,039.17 ₮

Олгосон санхүүжилт
3,533,050.26 ₮

Гүйцэтгэсэн ажлын дүн
6,692,201.66 ₮

Азийн Хөгжлийн банк МОН-3099 хөнгөлөлттэй зээл



Гэрээний дүн
9,488,396.42 ₮

Олгосон санхүүжилт
6,668,102.01 ₮

Гүйцэтгэсэн ажлын дүн
7,693,489.96 ₮

Азийн Хөгжлийн банк МОН-0380 Буцалтгүй тусламж



Гэрээний дүн
3,698,952.00 $

Олгосон санхүүжилт
2,629,022.70 $

Гүйцэтгэсэн ажлын дүн
3,514,004.40 $

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар



Нийслэлийн батлагдсан төсөв
30,338,362,605.00 ₮

Олгосон санхүүжилт
20,550,533,499.22 ₮

Захирамжын гүйцэтгэл
27,465,211,830.22 ₮

Европын Хөрөнгө Оруулалтын Банк FI-83097 хөнгөлөлттэй зээл



Гэрээний дүн
47,331,944,158.27 ₮

Олгосон санхүүжилт
12,100,114,851.01 ₮

Гүйцэтгэсэн ажлын дүн
27,117,884,292.77 ₮

6. ДҮГНЭЛТ, АСУУДЛУУД

- 2018 оны 09-р сарын 15-ны байдлаар төслийн нэгдүгээр үе шатны хүрээнд хийх ажил гүйцэтгэл 57.78%-тай хэрэгжиж байгаа ба 2019 оны дунд үе гэхэд бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

- Төслийн Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа нь 2018 оны 10-р сард бүрэн дуусгасан байхаар төлөвлөн ажиллаж байна.

- Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил удаашралтай байгаа нь худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд саад болж байна. Гэхдээ 2018 оны 09-р сарын 15-ны байдлаар нийт 26 ажил, барааны багцуудын тендерийн үнэлгээний ихэнхийг АХБ баталсан.

Төслийн ажил гүйцэтгэлийн хүрээнд 2018 онд богино хугацааны барилгын улирлыг алдахгүйг зорин, ажлыг хурдацтай явуулах нөхцөл боломжоо бүрэн дайчлан ажиллаж байна.